

## УЛААНБААТАР ХОТЫН ХҮЙТНИЙ УЛИРЛЫН АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОЙМ /2024 ОНЫ 10 ДУГААР САР/

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 19 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ), азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ),  $\text{PM}_{2.5}$ ,  $\text{PM}_{10}$  тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл ( $\text{CO}$ ), озон ( $\text{O}_3$ ) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлж байна.


2024 оны хүйтний улирал 10 дугаар сарын Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2023 оны 10 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад  $\text{PM}_{10}$  тоосонцор  $20 \text{ мкг/м}^3$ -ээр буюу 19%-иар бага байна.

Харин  $\text{PM}_{2.5}$  тоосонцор  $3 \text{ мкг/м}^3$ -ээр 13%-иар, хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ) нь  $10 \text{ мкг/м}^3$ -ээр буюу 37%-иар, азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ) нь  $10 \text{ мкг/м}^3$ -ээр буюу 27%-иар тус тус их байна.


### Хүснэгт 1. Агаар дахь бохирдуулах бодисын 2023-2024 оны 10 дугаар сарын дундаж агууламж

| Бохирдуулах бодисын нэр           | Агаарын чанарын стандарт<br>MNS 4585:2016 | Сарын дундаж агууламж, $\text{мкг/м}^3$ |                           |
|-----------------------------------|-------------------------------------------|-----------------------------------------|---------------------------|
|                                   | Хүлцэх агууламж, $\text{мкг/м}^3$         | 2023 оны<br>10 дугаар сар               | 2024 оны<br>10 дугаар сар |
| $\text{PM}_{2.5}$ тоосонцор       | 50                                        | 23                                      | 26                        |
| $\text{PM}_{10}$ тоосонцор        | 100                                       | 107                                     | 87                        |
| Азотын давхар исэл, $\text{NO}_2$ | 50                                        | 37                                      | 47                        |
| Хүхэрлэг хий, $\text{SO}_2$       | 50                                        | 27                                      | 37                        |

Улаанбаатар хотын 2024 оны 10 дугаар сарын агаар бохирдуулах гол бохирдуулагч бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг дараах зургуудаар харууллаа. (Зураг 1- 5)




Зураг 1. Хүйтний улирлын агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламж, 2024 оны 10 сар

**PM2.5 тоосонцор**


Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2021-2024 он

2024 оны 10 дугаар сард PM2.5 тоосонцрын дундаж агууламжийг агаарын чанарын хяналт шинжилгээний харуул тус бүрээр авч үзвэл агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас даваагүй байна (Зураг 2).

**PM10 тоосонцор**


Зураг 3. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2021-2024 он

2024 оны 10 дугаар сард PM10 тоосонцрын дундаж агууламжийг агаарын чанарын хяналт шинжилгээний харуул тус бүрээр авч үзвэл 1-р хороолол 24 мкг/м<sup>3</sup>-ээр, 100-н айл 9 мкг/м<sup>3</sup>-ээр, Цахилгаан станц 77 мкг/м<sup>3</sup>-ээр, Хайлааст 3 мкг/м<sup>3</sup>-ээр агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас тус тус их байна (Зураг 3).

**Азотын давхар исэл (NO<sub>2</sub>)**

Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2021-2024 он

2024 оны 10 дугаар сард Азотын давхар исэл (NO<sub>2</sub>) -ийн дундаж агууламжийг агаарын чанарын хяналт шинжилгээний харуул тус бүрээр авч үзвэл Баруун 4-н зам 107 мкг/м<sup>3</sup>-ээр, Толгойт 2 мкг/м<sup>3</sup>-ээр агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас тус тус их байна (Зураг 4).

**Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)**

Зураг 5. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2021-2024 он

2024 оны 10 дугаар сард хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)-н дундаж агууламжийг агаарын чанарын хяналт шинжилгээний харуул тус бүрээр авч үзвэл 1-р хороолол 39 мкг/м<sup>3</sup>-ээр, Толгойт 83 мкг/м<sup>3</sup>-ээр, Баянхошуу 5 мкг/м<sup>3</sup>-ээр агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас тус тус их байна (Зураг 5).

**УЛААНБААТАР ХОТЫН 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН  
ЦАГ АГААРЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ /2023 ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАВ/**

| № | Цаг уурын үзүүлэлт            | 2023 оны 10 дугаар сар | 2024 оны 10 дугаар сар |
|---|-------------------------------|------------------------|------------------------|
| 1 | Агаарын дундаж температур °C  | 4.3 °C                 | 2.0 °C                 |
| 2 | Салхины дундаж хурд, м/с      | 2.0 м/с                | 2.2 м/с                |
| 3 | Сарын нийлбэр хур тунадас, мм | 2.6 мм                 | 11.1 мм                |

**2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКСИЙН МЭДЭЭ,  
/АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРУУЛ ТУС БҮРЭЭР/**

